2020 ОНЫ ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАРАМЖАВЫН БАЯРМАГНАЙГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР.

2020-07-21

1. Монгол улсын хөгжлийн урт хугацааны зорилтын нотолгоонд суурилсан Алсын хараа 2050 хөтөлбөрийг үндэслэн үндэсний язгуур эрх ашиг, түүх соёл, уламжлал, эв нэгдэл, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хүний хөгжил, хууль ёс, шударга байдлыг дээдэлсэн тэгш тэнцвэртэй нийгмийг цогцлоон байгуулах зорилго агуулсан мөрийн хөтөлбөрийг үндэс болгон хэрэгжүүлнэ.

2. Хот, Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх иргэд олон нийтийн эрх ашигт хамааралтай томоохон хөрөнгө оруулалтын ажлуудыг дэмжиж ажиллана.

- Инженерийн шугам сүлжээг сайжруулах
- Авто замын өргөтгөл шинэчлэл
- Хүүхдийн тоглоомын талбай , ногоон байгууламж, хотын гэрэлтүүлгийг сайжруулж нэмэгдүүлнэ.
- Хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр утаагүй түлшний үйлдвэр байгуулах ,
- Үерийн далан, ус зайлуулах хоолойнуудыг шинэчлэх, нэмэгдүүлэх
- Хог хаягдлын менежментийг сайжруулах

3. Тойргийн иргэдийн нийтлэг эрх ашгийг эрхэмлэж, иргэд, олон нийтийн байгууллагын зүгээс тавьсан санал хүсэлтийг бодлого, шийдвэр гаргахад тусгуулж ажиллана.

-Цэцэрлэг сургуулийн барилга байгууламжийн засвар үйлчилгээ, ашиглалтыг сайжруулах

-Жижиг дунд бизнес эрхлэгчид болон өрхийн бичил аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжин ажиллана.Ажлын байрыг нэмэгдүүлнэ.

-Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран ажиллах, иргэдийн аюулгүй тав тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах

-Их спортыг дэмжин , спортын клубүүдтэй хамтарч ажиллана.

-Тойргийн сургуулийн гадна биеийн тамирын талбайд хоккейн талбай байгуулах

-Тойргийн шилэн кабелийн сүлжээ нэвтрээгүй байруудын Мобинет өрхийн интернет “VOO” үйлчилгээ нэвтрүүлэх / үүрэн холбооны компаниудтай хамтран ажиллана./

-Зайны цахим сургалтаар хэлний боловсрол эзэмших боломжийг олгох

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх сувилал, иргэдэд үйлчилгээ үзүүлдэг төвүүдийн үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллах

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг сургуулиудын тоног төхөөрөмж техник хэрэгслийн хангамжийг сайжруулах

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Д.БАЯРМАГНАЙ

6117143690
ФАА0073 3042606